

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 14

Хуралдаан 2013 оны тавдугаар сарын 9-ний өдрийн 14 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 21 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг нийт 06 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Сэлэнгэ аймагт ажилласан Ажлын хэсгийн тайлан</p> <ul style="list-style-type: none">- Сэлэнгэ аймагт ажилласан Ажлын хэсгийн танилцуулга- Сэлэнгэ аймагт зохион зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хамгийн өндөр авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Сэлэнгэ аймагт 2013 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 148 иргэн, үүнээс 15 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 133 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 8 иргэнийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 14 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын гурав, дөрөвдүгээр хавсралтаар баталсан нэр бүхий 22 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын журмыг шинэчлэн батлах тухай	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8, 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.9 дэх хэсгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ, дүн гаргах заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн хуудас"-ны загварыг гуравдугаар хавсралтаар, "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг нөөцөд</p>

		<p>бүртгэх жагсаалтын загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Бүртгэлийн хуудас”-ны загварыг тавдугаар хавсралтаар, “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын зохион байгуулалтын хяналтын хуудас”-ыг зургаадугаар хавсралтаар, “Өргөдлийн загвар”-ыг долоо дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулахдаа энэхүү журам, зааврыг баримталж ажиллахыг аймаг нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комисс, салбар комисст тус тус үүрэг болгох.</p> <p>3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>4. Энэхүү тогтоолыг 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none"> -Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга -Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга -Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга -Бодлогын хэрэгжилтийг зохицуулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.газрын дарга 	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Түдэвбазарын Баярбаясгаланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын, Бат-Очирын Гантулгыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Түмэндэмбэрэлийн Булганыг Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын</p>

		<p>даргын, Цанжидын Ширэндэв, Тэгшжаргалын Эрдэнэчимэг нарыг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд тус тус томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Түдэвбазарын Баярбаясгаланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын, Бат-Очирын Гантулгыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Түмэндэмбэрэлийн Булганыг Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын, Цанжидын Ширэндэвийг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболдод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын албан тушаалд Чойжилсүрэнгийн Тавинжилийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

5	Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн В.Дарханбаатараас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>“Албан тушаал бууруулах тухай” Төрийн өмчийн хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2013 оны Б/65 дугаар тушаалыг эс зөвшөөрч тус хорооны мэргэжилтэн В.Дарханбаатараас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, мөн зүйлийн 39.5 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “б”-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Албан тушаал бууруулах тухай” Төрийн өмчийн хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2013 оны Б/65 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. Маргаан хянан шалгасан комиссын дүгнэлт, дүгнэлтийн тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг Төрийн өмчийн хороонд болон тус хорооны мэргэжилтэн В.Дарханбаатарт тус тус хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Сангийн яамны Хууль худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б.Ганбат, Б.Батбаяр нараас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>“Б.Ганбат, Б.Батбаяр нарыг төрийн албанаас халах тухай” Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны Б/15 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч тус яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн асан Б.Ганбатаас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах</p>

		<p>комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, мөн зүйлийн 39.5 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “г”-д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none">1. “Б.Ганбат, Б.Батбаяр нарыг төрийн албанаас халах тухай” Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны Б/15 дугаар тушаалын Б.Ганбатад холбогдох хэсгийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.2. Маргаан хянан шалгасан комиссын дүгнэлт, дүгнэлтийн тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг Сангийн яаманд болон тус яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн асан Б.Ганбатад тус тус хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар шийдвэрлэв. <p>“Б.Ганбат, Б.Батбаяр нарыг төрийн албанаас халах тухай” Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны Б/15 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч тус яамны Санхүү бодлого, өрийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн асан Б.Батбаяраас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, мөн зүйлийн 39.5 болон Улсын Их</p>
--	--	---

		<p>Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “г”-д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Б.Ганбат, Б.Батбаяр нарыг төрийн албанаас халах тухай” Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны Б/15 дугаар тушаалын Б.Батбаярт холбогдох хэсгийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх. 2. Маргаан хянан шалгасан комиссын дүгнэлт, дүгнэлтийн тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг Сангийн яаманд болон тус яамны Санхүү бодлого, өрийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн асан Б.Батбаярт тус тус хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
7	<p>Зарим хүмүүсийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шалгаруулан шагнах тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан нэр бүхий 65 төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах 2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний

		<p>ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох.</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	<p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Төрийн нарийн бичгийн дарга, 2) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 3) Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 4) Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, 5) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, 6) Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хөгжлийн хэлтсийн дарга, 7) Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, 8) Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, 9) Аппаратын хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, 10) Яамны үйл ажиллагааны стратеги төлөвлөлт, хэрэгжилтийн нэгдсэн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, 11) Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн. <p>2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн</p>

		<p>135 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалын Хатанбаатарыг, нарийн бичгийн даргаар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Сэнгээгийн Гантуяаг тус тус томилох.</p> <p>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд чанд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ж.Хатанбаатар, нарийн бичгийн дарга С.Гантуяа нарт үүрэг болгох.</p> <p>3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 74 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	<p>Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй батлах. Үүнд:</p>

		<p>a. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, b. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, c. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, d. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, e. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, f. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, g. дарга, h. Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга, i. Нийслэлийн Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын газрын дарга, j. Нийслэлийн Аудитын газрын Аудитын хэлтсийн дарга, k. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, l. Нийслэлийн Боловсролын газрын дарга, m. Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, n. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, o. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн мэргэжилтэн, p. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн нарийн бичгийн дарга (орон тооны).</p> <p>2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

		<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ёндон-Ойдовын Гэрэлчулууныг томилох.2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд чанд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ё.Гэрэлчулуунд үүрэг болгох.3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 66 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

